

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНД БАРИМТЛАХ
БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ
/ 2025 оны жилийн эцсийн тайлан/

Д/д		Тэргүүлэх чиглэл	Хэрэгжилт	Үнэлгээ
1	2	3	4	5
		1.3.Бизнес, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна.		
		1.3.2.Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд:		
1	1.3.2.9	Бизнес эрхлэхэд тулгарч байгаа хүндрэл, бэрхшээлийг арилгах, хүний нөөцийн тулгамдсан асуудалтай холбогдуулан гадаадаас авах ажиллах хүчний хязгаарлалт, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх асуудлыг бодлогоор дэмжиж, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, зөвлөгөө өгөх цогц үйлчилгээг тогтворжуулна.	Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу “Монгол Улсад 2025 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 182 дугаар тогтоолыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр батлуулсан. Ингэхдээ Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д “Хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх” гэж заасны дагуу мөн Монгол Улсын эдийн засаг тэлж, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа өргөжихийн хирээр, нөгөө талд хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, ажиллах хүчний хомсдол бий болж байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ сэргэлтийн бодлого” болон бусад бодлого, зорилтын хүрээнд бизнес эрхлэлт, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, хөгжлийн төслийг хэрэгжүүлэхэд аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих шаардлагын дагуу Монгол Улсад 2025 онд хөдөлмөр эрхлэх гадаад ажилтны тоо, хувь хэмжээг гадаадын иргэний эрх зүйн байдлын хууль тогтоомжид нийцүүлэн төрийн удирдлага, батлан хамгаалах, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаанаас бусад салбаруудад хязгаарлалт тогтоохгүй байхаар шийдвэрлэсэн. Түүнчлэн “Ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын 2025 оны 31, 49, 96 дүгээр тогтоолуудаар Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх 57 аж ахуйн нэгж, байгууллагын 17562 гадаад ажилтныг 2025 онд ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх шийдвэр гарсан. Мөн гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотойгоор боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт	100

			оруулах хуулийн төсөлд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт ажиллах гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг эдийн засаг, бүтээн байгуулалтын бодлого, чиглэлийг харгалзан Засгийн газар тогтоох, мөн Засгийн газрын шугамаар авсан гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хүрээнд ашигт малтмал, газрын тосны салбарт төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд гадаад ажилтан ажиллуулах тохиолдолд Засгийн газар ажлын байрны төлбөрөөс хөнгөлж, чөлөөлөхөөр тусгасан болно. Мөн аж ахуйн нэгж, байгууллагууд гадаад улсаас ажилтан авч ажиллуулах урьдчилсан зөвшөөрлийн хүсэлт гаргахад тухайн ажлын байрыг нийтэд ажлын 14 өдөр зарласан байх зохицуулалт нь хүндрэлтэй байгаа тул дээрх хугацааг хүчингүй болгохоор тусгасан.	
3.4.Нийгмийн баталгааг сайжруулж, хүн амын бүлгийн онцлогт нийцсэн бодлогыг хэрэгжүүлнэ.				
2	3.4.1.	Нийгмийн даатгалын тогтолцоог, сайжруулан иргэн бүрд хуримтлалын сан бүрдүүлж, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар ашиглах, тэтгэврээ өвлүүлэх, урьдчилан ашиглах боломжийг бүрдүүлэх тэтгэврийн шинэчлэлийг үргэлжлүүлнэ.	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байх, 29.3.1-д тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний ажил олгогчийн 1.0, даатгуулагчийн 1.0, нийт 2.0 хувийн, энэ хуулийн 18.3-т заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээний 2.0 хувийн шимтгэлийн орлогыг тэтгэврийн нөөц санд төвлөрүүлэхээр заасан. Хуулийн энэхүү зохицуулалтын дагуу тайлант хугацаанд тэтгэврийн нөөц санд 1.1 сая даатгуулагчийн 301.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна. Түүнчлэн, тэтгэврийн нөөц санд байршуулсан даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг “Нийгмийн даатгал” аппликейшний “Миний тэтгэврийн мөнгөн хуримтлал” цэсээс цахимаар шалгах боломжийг бүрдүүлсэн.	100
3	3.4.2.	Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бэхжүүлж, Үндэсний баялгийн сангаар дамжуулан эрүүл мэнд, боловсрол, орон сууцжуулалт, хуримтлалын хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн платформ “E-Mongolia” платформоор дамжуулан иргэн бүрд хуримтлалын данс нээнэ.	Үндэсний баялгийн сангийн тухай хуулиар газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлэх замаар тэгш, шударга хүртээх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байхаар тооцож, хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг иргэн бүрд тэгш хуваарилж, уг мөнгөн хөрөнгийг хуримтлалын сангаар дамжуулан иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэхээр хуульчилсан. Үндэсний баялгийн сангийн тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн нэг жил гаруйн хугацаанд Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгө 2025 оны 11 дүгээр сарын сарын байдлаар 754.4 тэрбум төгрөгт хүрээд байна. 2025 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр сангийн үлдэгдэл 1,109.1 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтад “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэж, хөтлөх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт “Хуримтлалын сангийн дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг Монгол Улсын иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд бүртгэнэ” гэж тус тус заасныг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын иргэн бүрд хуримтлалын нэрийн данс үүсгэх, хөтлөх, сангаас зарцуулалт хийх” журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100

			Монгол Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганы хуралдаанаар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг хэлэлцэн баталсан. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын 3,565.9 мянган иргэнд Хуримтлалын нэрийн данс нээж, иргэн бүрт 138.9 мянган төгрөгийн ногдол ашгийг бүртгэсэн. Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар Хуримтлалын санд 2025 оны эхний хагас жилийн байдлаар төвлөрсөн мөнгөн хөрөнгийг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд бүртгэхээр шийдвэрлэсэн бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд 175.4 мянган төгрөг хуримтлагдаад байна. Харин “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2024 оны 2, 3 дугаар ээлжийн энгийн хувьцааны ногдол ашгаа Хуримтлалын нэрийн дансандаа шилжүүлсэн иргэний хуримтлалын нэрийн дансны эцсийн үлдэгдэл уг орлогоор нэмэгдэн бүртгэгдсэн. Иргэн бүр хуримтлалын нэрийн дансны мэдээллээ төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс шалгах боломжтой болсон. 2025 оны сүүлийн хагас жилд буюу 12 дугаар сард Хуримтлалын санд төвлөрсөн ногдол ашгийн орлогыг мөн иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хуваарилах юм. Хуримтлалын нэрийн дансанд бүртгэгдсэн ногдол ашгийн мэдээллийг төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол системийн Профайл цэсийн "Чингис Хаан" Үндэсний Баялгийн сан хэсгээс шалгах боломжтой болсон. Засгийн газрын 2024 оны 224 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Санхүүгийн мэдээллийн технологийн төв УТҮГ-тэй 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02/129, 2025/19 тоот Хуримтлалын нэгдсэн сангийн системийг хөгжүүлэх Хамтран ажиллах гэрээ, 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 02/130 тоот Систем ашиглалтын гэрээг тус тус байгуулан хамтран ажиллаж Хуримтлалын сангийн мэдээллийн нэгдсэн систем hurimtlal.gov.mn –ийг ашиглалтад оруулаад байна.	
4	3.4.4.	Хуримтлалын сангийн үйл ажиллагааг орон сууцны урт хугацааны санхүүжилттэй уялдуулах, тогтолцооны шинэчлэлийг эхлүүлнэ.	Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд 372.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлого, хүүгийн орлогоор 156,028.9 сая төгрөг төвлөрүүлэхээр, нийт 528,929.9 сая төгрөгөөр хуримтлуулахаар тус тус хуульчилсан бөгөөд Хуримтлалын санд төвлөрсөн орлогыг иргэн бүрийн хуримтлалын нэрийн дансанд хуваарилна. Түүнчлэн Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хөрөнгө оруулж ажиллана.	100
5	3.4.5.	Хөдөлмөр, нийгмийн үйлчилгээнд суурилсан нийгмийн халамжийн бодлогыг шинэчлэх хүрээнд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2024.12.20, 2025.09.25, 2025.12.09-ний өдрүүдэд Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 3 удаа хамтран баталсан. Нийгмийн халамжийн одоогийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, зарим хөтөлбөрийг нэгтгэх, хөдөлмөрлөх чадвартай боловч халамж хүртдэг иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, тэдэнд чиглэсэн	100

		нийгмийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа. Энэ хуулийн төсөлтэй хамт 21 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслүүдийг боловсруулсан. 2025 онд яамдаас ирүүлсэн 2 удаагийн саналыг тусган хуулийн төслийг сайжруулан боловсруулж Улсын Их хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болсон. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, зардлын тооцоо, дэлгэрэнгүй болон товч танилцуулга, үр нөлөөний үнэлгээ, хэлэлцүүлгүүдийн тайлан зэрэг иж бүрдлийг бүрэн хангасан. Мөн 2025 онд халамжийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн үйлчилгээг сайжруулах зорилгоор дараах эрх зүйн баримт бичгийг шинэчлэн болон шинээр батлуулан хэрэгжүүлж байна. Үүнд: -Ахмад настны асрамжийн үйлчилгээг шинээр үзүүлэх, барилга байгууламж барих аж ахуйн нэгж, байгууллагад төрөөс нэг удаагийн дэмжлэг үзүүлэх журам (Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 245 дугаар тогтоол) -Ахмад настанд асаргааны хувилбарт үйлчилгээ, идэвхтэй насжилтыг дэмжих “Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ батлах тухай” (Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2025 оны хамтарсан А51/А37 дугаар тушаал) -Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журам (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны хамтарсан А/76, А515 дугаар тушаал) -Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны хамтарсан А/76, А514 дугаар тушаал) Дээрх журмуудын хүрээнд нийгмийн үйлчилгээг сайжруулах зорилгоор улсын хэмжээнд Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлэх 37 байгууллага, гэрээр асрах болон өдрөөр асрах үйлчилгээ үзүүлэх 22 байгууллага, байнга асрах үйлчилгээ үзүүлэх 1 байгууллагыг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын мэдээгээр үйлчилгээнд нийт 21,541 ахмад настан хамрагдаж, 1.0 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилтийг нийгмийн халамжийн сангаас олгоод байна. -Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний аргачлал, заавар, үйлчилгээний үнэ тариф, гэрээний загвар (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/53 дугаар тушаал) -Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, журам (Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/35 дугаар тушаал) Энэ үйлчилгээний хүрээнд кейс менежментэд суурилан нийгмийн ажилтан зорилтот бүлгийн өрх, иргэнд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхээр тусгасан. 2025 оны 11 сарын	
--	--	---	--

			байдлаар 93 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж 3357 өрх, иргэнийг хамруулж 1.9 тэрбум төгрөг зарцууллаа. -Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх журам (Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/186 дугаар тушаал) Журмаар өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч ажил эрхлээгүй иргэнд дэмжлэг олгохгүй, харин хөдөлмөр эрхэлж буй гишүүдийг урамшуулж дэмжлэгийг олгоно. Өрх бүрд хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, өрхийг тогтмол орлоготой болгох замаар бие даан амьдрахад дэмжлэг үзүүлнэ.	
6	3.4.6.	Хувийн хэвшлийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтыг дэмжих хүрээнд гадаадаас ажиллах хүч авахтай холбогдуулан ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх, хөдөлмөр эрхлэх виз олгох зохицуулалтад дүн шинжилгээ хийж, шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг зарим салбарт чөлөөлөхтэй холбоотойгоор Засгийн газрын 2023 оны 45 дугаар тэмдэглэлээр Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад (хуучнаар) даалгасан. Мөн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.2.2.5-д “Өндөр мэдлэг, ур чадвар бүхий нарийн мэргэжлийн ажиллах хүчний болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг хангах зорилгоор гадаадаас авах ажиллах хүчний тоонд тавих хязгаарлалтыг уян хатан болгох, ажлын байрны төлбөрөөс бүрэн чөлөөлөх бодлого баримтална” гэж заасан. Дээрх Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах хүрээнд Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам эцэслэн боловсруулж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталж, хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.	100
7	3.4.7.	Хувийн нэмэлт тэтгэврийн даатгалын тогтолцоог бүрдүүлэх асуудлыг судалж, эрх зүйн орчныг сайжруулна.	Тэтгэврийн олон давхаргат тогтолцоонд шилжих, тэтгэвэр авагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой болох зорилтын хүрээнд Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/48 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төсөл, хуулийг дагаж өргөн мэдүүлэх 13 хуулийн төсөл болон холбогдох тооцоо судалгааг тус тус боловсруулсан. Хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 06 сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Харин Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан хуулийн төслүүдийг Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн хуралдаанд дахин хэлэлцүүлсэн бөгөөд Засгийн гишүүдийн гаргасан саналын дагуу хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулсан. Дээрх шийдвэрийг дагуу Хууль тогтоомжийн тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Хувийн нэмэлт тэтгэврийн хухай хуулийн төслийн үзэл баримтлалын	70

			төслийг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран батлахаар 2025 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 01/3077 дугаар албан бичгээр хүргүүлж, санал авсан. Яамдаас ирүүлсэн саналыг тусган Үзэл баримтлалын төслийг хамтран батлахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/3494 дүгээр, Сангийн яаманд 2025.12.03-ны өдрийн 01/3911 дугаар албан бичгээр тус тус дахин хүргүүлээд байна. Түүнчлэн, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд Хуулийн төслийг эцэслэн боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад даалгасан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	
8	3.4.8.	Үндэсний орон сууцжуулалтын бодлогыг шинэчлэх талаар холбогдох арга хэмжээ авна.	Үндэсний орон сууцжуулалтын бодлогыг шинэчлэх талаар холбогдох арга хэмжээг авах ажлын хүрээнд тус яамны Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны хөтөлбөрийг санхүүжүүлэх хэлбэрээр санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулж, арвижуулах арга хэмжээ авч Монгобанктай холбогдох гэрээг байгуулж хэрэгжүүлэн ажиллаж байна. (Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Монголбанк хооронд “Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг удирдах, арвижуулах ерөнхий гэрээ”-г 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр шинэчлэн байгуулсан.) Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрт хөрөнгө оруулж ажиллаж байгаа бөгөөд Хуримтлалын сангийн эх үүсвэрээр 2024 онд 4,158 өрх, 2025 оны 11 сарын байдлаар 2,019 өрх ипотекийн зээлд хамрагдаад байна.	100
9	3.4.9.	Халамжийн олон төрлийн бодлогын давхцалыг арилгаж, зорилтот бүлэгт чиглүүлнэ.	Нийгмийн халамжийг зорилтот хэсэгт чиглүүлэх, халамж болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогын уялдааг сайжруулах зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайдтай хамтран баталсан. Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг, дагаж өөрчлөлт орох 20 гаруй хуулийн төсөл болон хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ, зардлын тооцоо, дэлгэрэнгүй болон товч танилцуулга, үр нөлөөний үнэлгээ, хэлэлцүүлгүүдийн тайлан зэрэг иж бүрдлийг бүрэн хангасан. Хуулийн төсөлд нийгмийн халамжийн одоогийн хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж, зарим хөтөлбөрийг нэгтгэх, нэг өрхөд ногдож байгаа халамжийн төрлүүдийг судлан, олон төрөл байгаа тохиолдолд тодорхой хязгаартай болгох, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, үйлчилгээг сайжруулах асуудлыг тусгасан. 2026 онд энэ хуулийн төслийг УИХ-д өргөн барина. Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх хүрээнд 2025 онд: -Түлээ нүүрсний хөнгөлөлтийг ахмад настанд амьжиргааны түвшинтэй уялдуудан олгодог болсон; -Ахмад настны хүндэтгэл гэж жилд 2 удаа 10000 төгрөг олгодог байсныг зогсоож, идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ үзүүлдэг болсон;	100

			-Байнгын асаргаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны тэтгэмжийг 142.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, мөн живхний үнийн хөнгөлөлт олгож эхэлсэн; -Ахмад настанд асаргааны хувилбарт үйлчилгээг амьжиргааны түвшинтэй уялдуулж, иргэнээс авах төлбөрийн хэмжээг ялгаатай тогтоосон; -Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх журмыг шинэчилсэнээр өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч ажил эрхлээгүй иргэнд дэмжлэг олгохгүй, харин хөдөлмөр эрхэлж буй гишүүдийг урамшуулж дэмжлэгийг олгоно. Өрх бүрд хөгжлийн төлөвлөгөө боловсруулж, хүүхдийг сургууль, цэцэрлэгт хамруулах, нийгмийн суурь үйлчилгээг сайжруулах, өрхийг тогтмол орлоготой болгох замаар бие даан амьдрах, ядуурлаас гарахад дэмжлэг үзүүлнэ.	
10	3.4.10.	Нийгмийн даатгалын сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг үе шаттайгаар ил тод, шилэн болгоно.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн олон нийтэд нээлттэй байршуулах, сангийн ил тод байдлыг хангах хүрээнд нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн 2008-2024 оны мэдээллийг https://shilen.gov.mn/ цахим хуудасны Засгийн газрын тусгай сангийн нээлттэй мэдээлэл хэсэгт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байршуулсан. Энэхүү нээлттэй мэдээлэлд тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сан, ажилгүйдлийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 16 жилийн орлого, зарлагын мэдээллийг аймаг, дүүргээр болон нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг байршуулсан банкны мэдээллийг агуулсан. Түүнчлэн, нийгмийн даатгалын сангийн мэдээллийг нээлттэй байршуулж, сангуудын засаглалыг сайжруулж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлж, хөрөнгийн менежментийг ил тод, шилэн болгох хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу Нийгмийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын тоог насны бүлгээр, даатгуулагчийн төрлөөр, Шимтгэл төлсөн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авагчдын тоог сан тус бүрээр, насны бүлгээр, зарцуулсан хөрөнгөөр, Хөдөлмөрийн чадвараа алдсан хүний тоо, Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага зэрэг 16 төрлийн мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүргээр 2022-2024 оны мэдээллийг нээлттэй өгөгдөл хэлбэрээр (.xlsx, .xml, .csv, .json) байршуулсан.	100
11	3.4.11.	Төрийн албан хаагчийн цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.	Монгол Улсын 2025 оны улсын төсөвт тусгасны дагуу Засгийн газрын 2024 оны 238 дугаар тогтоолоор инфляцын түвшинтэй уялдуулан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн албан хаагчдын үндсэн цалинг 6 хувиар нэмэгдүүлэн тогтоосон. Уг арга хэмжээний үр дүнд төрийн захиргааны болон төрийн мэргэжлийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээ 1,166.0 мянган төгрөг, төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээ 954.0 мянган төгрөг болсон. Түүнчлэн эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухааны салбарын нэмэлт хэлэлцээрийн дагуу 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс боловсролын салбарын албан хаагчдын үндсэн цалинг 50 хувиар, эрүүл мэндийн салбарын албан хаагчдын үндсэн цалинг 30 хувиар, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын үндсэн цалинг 20 хувиар тус тус нэмэгдүүлэхээр тохиролцсон. Бусад салбарын төрийн албан хаагчдын цалин хөлсийг үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	100

12	3.4.12.	Тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан жил бүр нэмэгдүүлнэ.	Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлэхээр заасан. Энэ хүрээнд Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 221 дүгээр тогтоолоор 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа тэтгэврийн хэмжээг 6 хувиар тус тус нэмэгдүүлсэн. Энэхүү арга хэмжээнд нийт 505.6 мянган тэтгэвэр авагч хамрагдаж, тэтгэврийн нэмэгдэлд 300.0 тэрбум төгрөг зарцуулсан. Ингэснээр дундаж тэтгэврийн хэмжээ 859.5 мянга, бүрэн тэтгэврийн доод хэмжээ 689.0 мянга, хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ 572.4 мянган төгрөгт тус тус хүрсэн. Түүнчлэн, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн тэтгэвэр авагчийн авч байгаа дундаж тэтгэврийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 8.6 хувиар нэмэгдүүлэхэд шаардагдах 477.9 тэрбум төгрөгийг баталсан. Энэ хүрээнд бүх төрлийн тэтгэврийг нэмэгдүүлэх тооцоолол хийн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Засгийн газрын “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 01/3943 дугаар албан бичгээр санал авч байна. Нийгмийн халамж: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 2024 оны 247 дугаар тогтоолоор нийгмийн халамжийн тэтгэвэр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн батлуулсан. Тогтоолын хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг 6 хувиар буюу 22.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, сард олгох хэмжээг 397.5 мянган төгрөгөөр, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэнд олгох тэтгэмжийн хэмжээг 142.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 445.0 мянган төгрөгөөр тус тус тогтоон олгосон.	100
13	3.4.13.	Малчдын орлогын эх үүсвэртэй уялдуулж, нийгмийн хамгааллын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	Орлогыг орлуулан тооцох хосолмол аргачлалаар Монгол Улсын өрх, иргэний амьжиргааны түвшний мэдээллийн нэгдсэн санг 50 гаруй төрлийн захиргааны мэдээллийг нэгтгэн 2025 онд шинэчлэн бүрдүүллээ. Энэ санд Монгол Улсын 3.5 сая иргэн, 988.0 мянган өрхийн мэдээлэл багтсан. Мэдээллийн санд үндэслэн өрх тус бүрийн амьжиргааны түвшний оноог тооцож, ядуурлын шугамаас доош орлоготой өрхүүдийг тогтоолоо. Үндэсний статистикийн хорооны Мал тооллогын мэдээллийн сангаас мал бүхий өрх, иргэний малын тоог төрлөөр, мөн малын тоо толгойг бодод шилжүүлснээр тооцож, өрхийн амьжиргааны түвшинг үнэлэх нэг шалгуур болгосон. Малчин өрхүүд нь хүүхдийн мөнгө болон бусад хуульд заасан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт үйлчилгээнд хамрагдаж байна.	90

			Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай малчин өрхийн амьжиргааны түвшин босго онооноос доош байвал хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийг үзүүлж байна. Малчид уур амьсгалын өөрчлөлтөөс улбаатай байгалийн гамшиг болон цочролд өртөж амьжиргааны эх үүсвэрээ алдах тохиолдолд онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 1.2 сая төгрөгийг олгож байна. Цаашид нийгмийн халамжийн үйлчилгээг гамшгаас урьчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, нийгмийн хамгааллын арга хэмжээг сайжруулах чиглэлээр Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган УИХ-д өргөн барихаар бэлдсэн.	
14	3.4.15.	Жижиг, дунд, бичил бизнесийг дэмжих урт хугацаатай, хүү багатай зээлийн бүтээгдэхүүний төрөл, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд зориулсан зээл, санхүүгийн дэмжлэгийг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.8 дахь заалтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжсэн. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг уялдуулах хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйн улмаас хөтөлбөрийг албажуулах ажил хойшилж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдан гарах хуулийн өөрчлөлтийн төсөлд холбогдох зохицуулалтыг тусгахаар ажиллаж байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар 2025 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа /хөтөлбөр/-г баталсан. Хөтөлбөрт хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих зорилготой санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж, 3300 иргэнийг хамруулж, 37.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 6000 иргэн хамрагдаж, 36.1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Түүнчлэн хувиараа хөдөлмөр эрхлэгч, гарааны бизнес эрхлэгчийг дэмжих жижиг, дунд бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоолоор батлуулсан.	90
	3.4.17	Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулан хөгжүүлнэ.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хурлын танхимд 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл, санхүүгийн дэмжлэг авсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагууд үйл ажиллагаагаа тогтворжуулах, хөгжүүлэхэд бизнес инкубацийн үйлчилгээний гүйцэтгэх үүрэг, ач холбогдлын талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын бизнес инкубаторуудын үндэсний нэгдсэн холбоо, “Старт ап Монголиа” ТББ, “Хөгжлийн шийдэл” ТББ-ын төлөөлөл, Их, дээд сургуулиудын багш нар, Монголын технологийн үндэсний парк, шинжлэх ухааны	70

15			академийн төлөөллүүд оролцсон бөгөөд Олон улсад бичил, жижиг бизнесийг бизнес инкубацийн үйлчилгээгээр дэмжин ажилладаг. Манай улсын тухайд энэ чиглэлээр өмнө хэрэгжүүлж байсан хөтөлбөрийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэх, санхүүжилтийг тогтвортой байлгахад анхаарах шаардлагатай байгаа талаар санал нэг байгаагаа илэрхийлсэн. Мөн цаашдаа Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг мэргэжлийн байгууллагуудаар хэлэлцүүлэх, хуулийн төсөлд бизнес инкубацийн үйлчилгээний талаарх зохицуулалтыг оновчтой тусгах талаар санал нэгдлээ. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн хурлаар Бизнес инкубацийн хөтөлбөрийг хэлэлцүүлэн батлуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 10 Бизнес инкубаци төвийг байгуулж 100-120 бойжигчийн бизнесийг дэмжиж, үйл ажиллагааг тогтворжуулах юм. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар Бизнес инкубаци төвийг сонгон шалгаруулах зарын дагуу тендерийн материалыг хүлээн авч сонгон шалгаруулалтыг хийж байна.	
16	3.4.18	Хиймэл оюун ухааныг ашиглан иргэн бүрийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн нийгмийн үйлчилгээг нэвтрүүлнэ.	Хиймэл оюун нэвтрүүлэх үйлчилгээний нөхцөл байдлын үнэлгээ, бизнес процессын шинжилгээг хийж ажлын даалгаврыг боловсруулсан. 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар тухайн арга хэмжээний санхүүжилт хасагдсан тул хэрэгжүүлэх боломжгүй болсон.	ү/б
17	3.4.19.	Өсвөр үеийн охид, хөвгүүдийн дунд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх, үе тэнгийн зөвлөгч бэлтгэх, тэднээр дамжуулан мэдээллийг өсвөр үеийнхэнд хүргэх, шаардлагатай үйлчилгээнд зуучлах нууцлалтай чатбот үйлчилгээг хөгжүүлнэ.	Хүүхдийн тусламжийн утас 108 дуудлагын төв нь Чатбокс, мессеж үйлчилгээг 2021 онд нэвтрүүлсэн. 2021 оноос хойш Чатбокс үйлчилгээнд нийт 7732 мэдээлэл хүлээн авч харьяа Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, хэлтэст шилжүүлэн ажилласан. 1/ Хагас жилийн байдлаар Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвд нийт 42,900 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн. Үүнээс 26,676 зорилтот дуудлага, мэдээлэл байна. Үүнээс хүүхэд, өсвөр үед зөвлөгөө өгсөн дуудлага 2385 дуудлага байна. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол талаар зөвлөгөө авсан хүүхдийн тоо - 467 байна. 2/ Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн цахим хуудсаар түгээсэн зөвлөгөө, мэдээллийн хандалт 43,796, постор мэдээллийн хандалт 21,496 байна. Мөн цахим орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар зөвлөгөө мэдээлэл, хууль эрх зүйн зөвлөгөөний талаарх 3 шторк бичлэгийг 22,300 хүнд хүргэсэн байна.	70
18	3.4.20.	Нийгмийн бүхий л орчинд хүүхдийн сайн сайхан байдлыг хангаж, болзошгүй эрсдэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэн, гэр бүл төвтэй, салбар дундын хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог бэхжүүлнэ.	1/ 2025 оны байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 36504 хүүхдэд хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлт гарган хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг бүрэн хүргэж, үр дүн гарсан 27082 хүүхдийн кейсийг хааж, шийдвэрлэлт 74.1 хувьтай байна. Хүүхэд хамгааллын кейс менежментийн төлөвлөлтийн дагуу хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үргэлжлүүлэн үзүүлж байгаа 9422 хүүхэд байна. 2/ Аймаг, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар хэлтсээс Хамтарсан багийн гишүүд, боловсролын, халамжийн, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтнуудад хүүхэд хамгааллын кейс менежментийн арга зүйг түгээх сургалтыг сум, хорооны Засаг	100

			дарга, Хамтарсан багтай хамтран зохион байгуулж, 9 дүүргийн 225 хороо, 17 аймгийн 122 сумын 602 хамтарсан багийн 2882 гишүүдэд хүргэсэн. З/ГБХНХЯ, Сангийн яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар хамтран Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, хүүхэд хамгааллын үйлчилгээний нэг хүүхдэд ногдох дундаж зардлын норматив”, Хүүхэд хамгааллын тухай хуулийг даган батлагдсан журам, стандартыг хэрэгжүүлж, мөрдөх арга зүйн сургалт зохион байгуулж, аймаг, нийслэл, дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар/хэлтсийн 120 албан хаагч, сум, хорооны 623 нийгмийн ажилтан хамрагдан чадавхжсан.	
19	3.4.21.	“Цалинтай эх, эцэг” нийгмийн хамгааллын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно.	Гэр бүлийг дэмжих тухай анхдагч хуулийн төсөлд 0-2 насны хүүхдээ асарч байгаа эцэг, эхэд олгох мөнгөн дэмжлэгийг үргэлжлүүлэн олгохоор тусган 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон. Гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөнгөн дэмжлэгийн үр нөлөөнд дөрвөн жил тутамд үнэлгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах бөгөөд Засгийн газар шаардлагатай гэж үзвэл мөнгөн дэмжлэгийг зогсоох, нэгтгэх, мөнгөн дэмжлэг шинээр бий болгох асуудлыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр хуулийн төсөлд тусгасан. Мөн, Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хуулийн төсөлд Нийгмийн халамжийн хуулийн дагуу хүүхэд, эх, гэр бүлд тэтгэмж олгох, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг шагнах, урамшуулахтай холбогдсон харилцааны зохицуулалтыг тусгасан. ГБХДТХ-ийн үзэл баримтлалыг ХЗДХ-ын сайдтай 3 дахь удаагаа 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр батлуулсан.	90
20	3.4.22.	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг баталж, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагын оролцоонд тулгуурлан хэрэгжүүлнэ.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь жил бүр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн хурлаар хүн амын бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэлэлцүүлэн батлуулдаг. 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр ХЭҮЗ-ийн хурлаар 2025 онд хэрэгжүүлэх Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих йл ажиллагааг 01 дүгээр тогтоолоор баталсан. Үүний дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/50 дугаар тушаалаар Нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг баталсан. Уг үйл ажиллагааны хүрээнд Гэрээс зайнаас ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ур чадварын цахим сургалтыг зохион байгуулахаар тусгасан. Мөн Бага насны /0-8 нас/ хүүхэдтэй ээжүүдийг дэмжих зорилгоор 10 хүртэлх сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг тусгасан. -Түүнчлэн Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг боловсруулж, батлуулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, эмэгтэйчүүдийн болон иргэний нийгмийн байгууллагуудын санал, дуу хоолойг сонсох ажлыг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудал болон хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэл хамтын ажиллагаа сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр	70

			зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах ТББ-ууд, ОУБ, Төрийн байгууллагын төлөөллүүд оролцсон. Монгол Улсад өнөөдөр 1 сая 196 мянган хүн ажиллаж байгаагийн 563 мянга нь эмэгтэйчүүд, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 48.6 хувь байгаа нь эмэгтэйчүүд үр хүүхэд, гэр бүлийн хүн, ахмад настнаа асрах зэрэг цалин хөлсгүй асрахуйн ажилд их цаг зарцуулдаг. Судалгаагаар Ази номхон далайн орнуудын эмэгтэйчүүд дэлхийн бусад улстай харьцуулбал 4 дахин их цагийг үнэ төлбөргүй асрахуйн ажилд зарцуулдаг байна. Ажиллах хүч дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр дотоодын нийт бүтээгдэхүүнийг 26 хувиар өсгөх боломжтой. Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 15 аймаг, 6 дүүргийн хүүхэд харах үйлчилгээний төвд 315 хүүхэд асрагч эмэгтэйчүүд ажиллаж байна. Цаашид Монгол Улсад Асрахуйн эдийн засгийг хөгжүүлж, эмэгтэйчүүдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, эрх тэгш, хүртээмжтэй, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулдаг нийгмийг бий болгохыг зорих зэрэг асуудлыг хөндөж санал, зөвлөмжөө хуваалцлаа. -2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” ТББ-ын зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон эмэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, санал солилцсон. -ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.1.13-т заасан “Эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.” зорилтын хүрээнд "ЭХЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН НИЙГМИЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ арга хэмжээтэй уялдуулан салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг тус хөтөлбөрт тусгахаар ажиллаж байна.	
21	3.4.23.	Эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.	Гэр бүлийг дэмжих анхдагч хуулийн төслийг боловсруулж байна. Энэхүү хуулийн төслийн хүрээнд гэр бүлийг дэмжих цогц төвүүдийг аймаг, дүүрэг бүрт байгуулахаар төлөвлөж байна. Цогц төвөөр үйлчлүүлэх эхчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн цогц үйлчилгээний хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 25 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 10 дугаар сарын 27-ны А/284 дугаар тушаалаар батлуулсан. Эхчүүд эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн үйлчилгээний цогц хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн хурлыг 2025.11.11-ний өдөр зохион байгуулсан. Хөтөлбөрийн дагуу Эмэгтэй удирдагч сан ТББ-ын тэргүүн С.Болормаа "Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах талаар авч хэрэгжүүлж байсан арга хэмжээний талаар", ГББГ-ын ахлах шинжээч С.Цогтбаатар "Гэр бүлийн хөгжлийн цогц үйлчилгээний төв ажиллуулах заавар, зөвлөмж" -ийн талаар, ГББГ-ын ахлах шинжээч М.Одонцэцэг "Эхчүүд, эмэгтэйчүүдэд зориулсан нийгмийн цогц үйлчилгээний хөтөлбөрийн төсөл" -ийн талаар тус тус танилцуулга хийсний дараа нэгдсэн хэлэлцүүлэг хийсэн. Тус хөтөлбөрийн зорилго нь охид, эмэгтэйчүүд, эхчүүдийн эрүүл мэнд, боловсрол, эдийн засаг, нийгмийн хамгаалал, сэтгэл зүйн дэмжлэг зэрэг олон талт хэрэгцээнд нь суурилсан цогц үйлчилгээг төр, хувийн хэвшил болон мэргэжлийн байгууллагуудын хамтын оролцоонд тулгуурлан хүртээмжтэй, үр нөлөөтэй хүргэх замаар тэдний хөгжил, хамгааллыг дэмжихэд оршино. Тус хөтөлбөрт мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээ, сургалтын арга хэмжээ болон Эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллыг дэмжих үйлчилгээ гэсэн үндсэн 3 арга хэмжээнээс бүрдэх төдийгүй, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, хүүхэд харах үйлчилгээг цогцоор	70

			нь багтааж өгснөөрөө нэг цэг дээрээс эмэгтэйчүүд эхчүүд өөрт хэрэгцээт үйлчилгээндээ хамрагдах боломж бүрдэх юм. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд охид, эмэгтэйчүүд эрүүл мэнд, боловсрол, эдийн засаг, сэтгэл зүй, хамгааллын хэрэгцээнд суурилсан цогц үйлчилгээг авч, өөрийн нөөц боломжоо бүрэн ашиглах чадавхтай, хамгаалагдсан, идэвхтэй оролцоот иргэн болон хөгжих нөхцөл бүрдэнэ. Мөн хөтөлбөр нь эмэгтэйчүүдийн амьдралын чанарыг сайжруулж, хөдөлмөр эрхлэлт, орлого, аюулгүй байдал, нийгмийн оролцоог нэмэгдүүлэх бодит үр нөлөө гарна гэж үзэж байна.	
22	3.4.24.	Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагын оролцоог дэмжинэ.	Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, төрийн бус байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагын оролцоог дэмжинэ. Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлан 2025 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Уг хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ахмад настанд цогц үнэлгээ хийж 1-3 түвшинд үнэлэн, шаардлагатай үйлчилгээг тодорхойлон дараах төрлийн хувилбарт үйлчилгээ үзүүлэхээр хуульчилсан. Үүнд: - Гэрээр асрах үйлчилгээ. - Өдрөөр асрах үйлчилгээ. - Асралт гэр бүлээр асрах үйлчилгээ. - Түр хугацаагаар асрах үйлчилгээ. - Урт хугацаагаар асрах үйлчилгээ. - Байнга асрах үйлчилгээ. - Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ. Хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” А/76, А/515 дугаартай тушаалын хавсралтаар “Ахмад настанд цогц үнэлгээ хийх, тусламж үйлчилгээ үзүүлэх журам”, Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн “Журам батлах тухай” А/75, А/514 дугаартай тушаалын хавсралтаар “Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ууд батлагдсан. Мөн Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн “Үйлчилгээний жишиг үнэ, иргэний хариуцах төлбөрийн хэмжээ батлах тухай” А51/А37 дугаар хамтарсан тушаалаар хувилбарт үйлчилгээ үзүүлэх тариф батлагдсан. Батлагдсан хууль, журмын хүрээнд ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ үзүүлэх байгууллагын сонгон шалгаруулалтыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсээс зохион байгуулж, шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээний төрөл болох Гэрээр асрах буюу явуулын үйлчилгээ, байнга байрлуулан асрах үйлчилгээг нийт 23 аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага гэрээлэн гүйцэтгэж ахмад настны цогц үнэлгээгээр 3 дугаар түвшний, шаардлагатай бол 2 дугаар түвшинд үнэлэгдсэн ахмадуудад үйлчилгээ үзүүлж байна. 2025 оны 10 дугаар сарын тайлангаар улсын хэмжээнд гэрээр болон өдрөөр асрах үйлчилгээний байгууллага нийслэл хотод 8, орон нутагт 14 байгууллага, байнга асрах	100

			үйлчилгээг нийслэлд 1 байгууллага, улсын хэмжээнд нийт 23 байгууллага гэрээлэн гүйцэтгэж байна. Гэрээр асрах, Өдрөөр асрах үйлчилгээнд нийт 1,119 ахмад хамрагдсан бол Нийслэлийн Баянзүрх дүүрэгт Жаргалан эдлэн асрамжийн газарт байнга асрах үйлчилгээнд 43 ахмад настанг байруулан асаргаа, сувилгаа үзүүлж байна.	
23	3.4.25.	Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төслийг боловсруулан, батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш, хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг албан байгууллага, бүх төрлийн орон сууц, худалдаа, үйлчилгээний байгууллагад мөрдүүлнэ.	ГБХНХ-ын сайдын 2025 оны А/22 дугаар тушаалаар Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсгийн хурлыг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж, хуулийн төслийн холбогдох баримт бичгийн төсөл болох зардлын тооцоо, хэрэгцээ шаардлагын тандалт судалгааг боловсруулсан. Мөн дагалдан гарах 20 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төсөл, холбогдох судалгааг боловсруулан үзэл баримтлалыг батлуулахад бэлэн болгож, 2025 оны 09 дүгээр сард УИХ-ын гишүүн О.Саранчулууны ажлын албанд хүлээлгэн өгсөн.	90
24	3.4.26.	Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттайгаар нэвтрүүлэн, салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.	Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-ыг ашиглаж буй салбаруудын өнөөгийн байдал, цаашдын хамтын ажиллагааны талаарх салбар дундын уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлалыг үе шаттай нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, Эрүүл мэндийн яам, Боловсролын яамтай хамтран ажиллах талаар ярилцсан. Мөн хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тогтоож байгаа өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтэд Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-тай уялдуулан шинэчлэхээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/207 тоот тушаалаар “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж эхэлсэн. Хөдөлмөр эрхлэх сонирхолтой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүртгэх, хэрэгцээ, ур чадварт нийцсэн үйлчилгээ үзүүлэх стратегийг боловсруулах, суурь мэдээллийг цуглуулах 2 үе шаттай бүртгэл, судалгааны ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж 1-р үе шат болох цахим бүртгэлд 50,000 гаруй хүн хамрагдсан. 1-р үе шатанд хөдөлмөр эрхлэх сонирхолтойгоо илэрхийлсэн гэсэн 15,400 гаруй иргэдээс 2-р шатанд асуумжийн аргаар судалгааг авч нэгтгэж байна. Уг судалгааны асуулгад үйлдлийн чадамжийг тогтоох асуулгыг багтаасан. Мөн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөс үйлчилгээ авах иргэдийн үнэлгээнд хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-ыг ашиглахаар 120 гаруй иргэдийг хамруулсан туршилтын үнэлгээ хийсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэх чадварыг үнэлэх маягт, аргачлалыг хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-д суурилан хөгжлийн бэрхшээлийн 4 төрөл /Хараа, сонсгол, хөдөлгөөн, оюун ухаан/-д үнэлгээний хуудас, арга аргачлалыг боловсруулсан.	70

			2025 оны 12 дугаар сарын 9–11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Хөгжлийн бэрхшээлийн үйлдлийн чадамжийг тогтоох олон улсын аргачлал (ICF)-ын хэрэгжилт, салбар хоорондын хэрэглээний талаарх оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт”-д “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын үйл ажиллагаанд ICF-ыг ашиглах нь” сэдвээр илтгэл бэлтгэн оролцлоо.	
25	3.4.27.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн халамж, үйлчилгээний чанарыг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг хувийн хэвшилтэй хамтран бүх аймаг, дүүрэгт байгуулна.	Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн үйлчилгээг хүндрэл, чирэгдэлгүй болгох, хэрэгжилтийн явцад тулгамдаж байгаа зарим асуудлыг сайжруулах зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулав. Үүнд; 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх үйлчилгээг хүндрэл, чирэгдэлгүй болгох зорилгоор Нийгмийн халамжийн ehalamj.mn, E-Mongolia системээс гарах боломжтой мэдээллийг иргэнээс давхар цаасан хэлбэрээр шаардахгүй; 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тусламж, хөнгөлөлтөд хамруулах үйл явцын шат дамжлагыг багасгах зорилгоор Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхгүй болгох; 3. Асрамжийн газар, сэтгэцийн төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт удаан хугацаагаар хэвтэн эмчлүүлж байгаа эсхүл хорих ангид ял эдэлж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг тухайн байгууллагын нийгмийн ажилтан уламжлан хүсэлт гаргаж тусламж, хөнгөлөлтөд хамруулах; 4. Хүүхдийн комиссын шийдвэрийг үндэслэн байнгын асаргаа шаардлагатай өдөр тутам живх хэрэглэдэг 2-оос дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 3 жилд нэг удаа олгох живхний үнийн хөнгөлөлтийг Засгийн газраас тогтоосон жишиг үнэд багтаан хувааж, жилд нэг удаа олгох; 5. Хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрийн сонгосон протезийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх байгууллага, эмийн сангаас протез, ортопед, тусгай хэрэгслийг худалдан авах эсхүл хийлгэх; 6. Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусламж, хөнгөлөлт олгох, санхүүжүүлэх, тайлагнах явцыг цахимжуулах, иргэний сэтгэл ханамжийн судалгааг авах, хяналт үнэлгээг сайжруулах зэргийг журмын төсөлд тусгаад байна. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хүрээнд Баянзүрх дүүрэг, Завхан аймагт Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барьж, 2026 оны 09 дүгээр сард ашиглалтад оруулахаар 2025 онд Төслийн удирдах хорооны хурлаар барилгын ажлын гүйцэтгэлд 30 хувийн санхүүжилт болох нийт 5,6 тэрбум батлагдсан ч Сангийн яамнаас 2025 оны санхүүжилтийн дээд хязгаарыг тогтоож, тус 2 барилгын ажилд төсөв тусгагдаагүй болно. Дээрх 2 төвийн барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулсан. Үүнд: 1. Завхан аймагт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Морин сувд” ХХК-тай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 02/176 тоот гэрээг байгуулсан.	100

			2. Баянзүрх дүүрэгт баригдах Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/209 тоот тушаалаар батлуулж, тендерийг зарлаж, хамгийн сайн тендерээр үнэлэгдсэн “Хөххайрхан трейд” ХХК-тай 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр 02/156 тоот гэрээ байгуулсан. Мөн Өмнөговь аймаг дахь хөгжлийн төвийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын харьяанд ажиллуулахаар Засгийн газрын холбогдох тогтоолыг батлуулсан. Архангай аймаг дахь төвийн барилгыг 2025 оны 12 дугаар сард багтаан хүлээн авахаар Улсын комисст хүсэлтээ уламжилсан.	
26	3.4.28.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтын хүрээнд өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 4 хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/102 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд улсын үзлэг зохион байгуулах удирдамжийн хүрээнд яам, агентлаг, аймаг, дүүрэг дэх газар, хэлтсүүдийн Хөдөлмөрийн хяналтын улсын (ахлах) байцаагч нар 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэв. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 25, түүнээс дээш ажилтантай төрийн, хувийн болон гадаадын хөрөнгө оруулалттай 1018 аж ахуйн нэгж, байгууллагыг үзлэгт хамруулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй зөрчилтэй 154 аж ахуйн нэгж, байгууллагад 1,390,973.0 (нэг тэрбум гурван зуун ерэн сая есөн зуун далан гурван мянга) төгрөгийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлэх хөдөлмөрийн хяналтын улсын /ахлах/ байцаагчийн нөхөн төлбөрийн акт тавьсан байна. Өнөөдрийн байдлаар актын биелэлт 67.5 хувь буюу 939,587.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна. Мөн Зөрчлийн тухай хуулийн 10.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан буюу Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дах хэсгийг зөрчсөн 56 аж ахуйн нэгж, байгууллагад 84,000.0 (наян дөрвөн сая) мянган төгрөгийн шийтгэл ногдуулж (Улсын төсвийн хяналт шалгалтын орлогын дансанд), 494 албан шаардлага, 353 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Үзлэгт хамрагдсан 25, түүнээс дээш ажилтантай нийт байгууллагын 63,6 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг зохих орон тоонд ажиллуулаагүй, ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд санд төвлөрүүлээгүй буюу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 25, түүнээс дээш ажилтантай 6885 байгууллага (төр, хувийн хэвшлийн)-ын 1884 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг төлдөг, бусад 5041 байгууллага нь зохих төлбөрийг төлдөггүй, ажиллуулбал зохих орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажиллуулдаггүй байна. Улсын үзлэгт эдгээр байгууллагийн 20,2 хувь хамрагдаж, улсын байцаагчид 5,7 хувьд нь зөрчлийн арга хэмжээ тооцож, 48,5 хувьд нь зөрчил дутагдлыг арилгуулах албан шаардлага хүргүүлсэн байна. Үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар цаашид авах арга хэмжээний саналыг Төрийн албаны зөвлөл, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, яамны гэр бүлийн бодлогын газарт албан бичгээр хүргүүлсэн. Улсын үзлэгт Зөвлөн туслах үйлчилгээг	90

			үзүүлэх 4 төрийн бус байгууллагыг сонгон шалгаруулж, 186,160,000 төгрөгийн гэрээг байгуулсан.	
27	3.4.34.	Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэний нийгмийн баталгааг хангах үүднээс нийгмийн хамгааллын хэлэлцээрийг үргэлжлүүлэн байгуулна.	Монгол Улс нийгмийн хамгааллын чиглэлээр 6 улстай хэлэлцээр байгуулан хэрэгжүүлж байна. Түүнчлэн, Бүгд Найрамдах Казахстан Улстай 2024 онд хэлэлцээр байгуулж, 2025 хэлэлцээрийг соёрхон баталсан бол Бүгд Найрамдах Австри Улстай 2025 онд хэлэлцээр байгуулаад байна. Үүнд: 1. Улаанбаатар хотноо 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан “Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд 2025 10 дугаар сарын 30-ны өдөр өргөн мэдүүлсэн. Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай” хуулийг баталсан бөгөөд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн №47(1392) дугаарт нийтлэгдсэн. Хэлэлцээрийг БНКУ-ын парламентээс соёрхон баталж, энэ тухай Монгол Улсын талд мэдээлснээс дараагийн 2 дахь сараас хэрэгжүүлж эхэлнэ. 2. “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр”-ийн төслийг Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар тус тус хэлэлцэн дэмжсэн. Хэлэлцээрт Улаанбаатар хотноо 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гарын үсэг зурсан. Түүнчлэн, тус Хэлэлцээр нь заавал соёрхон батлах олон улсын гэрээ тул “Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн төслийг Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	100
28	3.4.35.	Эрэгтэйчүүдийн гэр бүлдээ зарцуулах цаг, оролцоо, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, ажил, амьдралын тэнцвэрт байдлыг хангасан хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.	Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хүүхэд асрах, гэр бүлдээ цаг зарцуулах, халамжлахтай холбоотой дараах зохицуулалтыг тусган батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд: 1. “137.5. Эцэгт шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10-аас доошгүй өдрийн чөлөөг ажил олгогч олгож, тухайн хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгоно. 139.1. Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна. 2. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны бүхий л арга	90

			хэмжээнд хүн амын бүлгүүдийн, тухайлбал эрэгтэйчүүдийн оролцоог хангах, тэдний бүрэн болон бүрэн бус цагаар хөдөлмөр эрхлэх боломжийг хангаж өгсөн. Тухайлбал хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд байнгын ажлын байранд зуучлах, цагийн ажил эрхлэхийг дэмжих, өрхийн бизнес, аж ахуй эрхлэх хүсэлтэй иргэнд санхүүгийн дэмжлэг олгох, аж ахуй эрхлэлтийн сургалтанд хамруулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.	
3.5.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг хүн амын бүлэгт зориулан оновчтой хэрэгжүүлнэ.				
29	3.5.1.	Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, эмэгтэйчүүдийн болон ганц бие эцэг, эхийн хөдөлмөр эрхлэлт, асрахуйн эдийн засгийг дэмжинэ.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчлэн найруулгыг УИХ-аар батлуулж 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн бөгөөд энэ хуулийн шинэчлэлийг Хүүхдийн эрхийн конвенцод нийцүүлэн боловсруулсан. Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар Хүүхэд харах үйлчилгээ, өдөр өнжүүлэх үйлчилгээний талаарх эрх зүйн асуудлуудыг нарийвчлан зохицуулсан бөгөөд хуулийг сурталчилах, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллаж байна. Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хуулийг даган гарах 10 дүрэм, журам, 5 стандартыг батлуулж, мөрдөж байна. Мөн зорилтод бүлэг, алслагдсан бүс нутаг, хилийн застав, цэргийн ангийн ажилтнуудын хүүхдийг хамруулах, ганц бие эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримтлан ажиллаж байна. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Хүүхэд харах үйлчилгээний 142 төвд 329 хүүхэд харагч ажиллаж, 1455 хүүхэд хамрагдсанаас 189 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсан байна. Сар бүр 16 аймаг, 6 дүүргээс хүүхэд харах үйлчилгээний журам, стандартын дагуу мэдээллийн санг шинэчилж, хүүхдийн ирцийн мэдээний маягт, бүртгэлийн хуудсыг хянан эхний хагас жилийн байдлаар 1,2 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон. Хүүхэд харах үйлчилгээг зорилтод бүлэг, алслагдсан бүс нутаг, хилийн застав, цэргийн ангийн ажилтнуудын хүүхдийг хамруулах, ганц бие эцэг эхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримтлан ажиллаж байна. Улсын хэмжээнд 13 аймаг, 6 дүүргийн 101 хүүхэд харах үйлчилгээний төвд 206 хүүхэд харагч ажиллаж байгаагаас 19 нь ганц бие эцэг, эх байна. Тус төвүүдэд 1203 хүүхэд хамрагдаж байгаагийн 142 нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна. Хүүхэд харах үйлчилгээг үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах мэргэжил арга зүйн удирдлагаар хангах танхим болон цахим сургалтад 275 хүүхэд харагч хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 59,9%-иар өссөн байна. Асрахуйн эдийн засгийг дэмжих хүрээнд хүүхэд харах үйлчилгээ эрхэлж буй ганц бие эцэг, эхийн судалгааг гаргахад 19 иргэн байна. Алслагдсан бүс нутаг, зорилтот бүлгийн 686 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй 189 хүүхэд хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66,9%-иар өссөн. Асрахуйн эдийн засгийг дэмжих хүрээнд 19 ганц бие эцэг эх Хүүхэд харах үйлчилгээ эрхэлж байна.	100

30	3.5.2.	Зайнаас болон цагаар ажиллах хөдөлмөр эрхлэлтийн уян хатан зохицуулалтыг бий болгон иргэн бүр орлоготой ажиллах боломжийг нэмэгдүүлнэ	Манай яам, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сантай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3, гэр бүлд ээлтэй хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг үнэлэх зорилгоор “Монгол Улс дахь гэр бүлд ээлтэй бодлогын хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”-г хийж байна. Тус судалгааг “IRIM” судалгааны хүрээлэнгээс гүйцэтгэж байгаа бөгөөд судалгааны зорилго нь Монгол Улс дахь төр, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүүхдэд ээлтэй бодлого, ажилтны ажил амьдралын тэнцвэрийг хангах зохицуулалт хэр түвшинд хэрэгжиж байгааг ажилтны хөдөлмөрийн бүтээмж, ажилдаа сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл бүрдсэн эсэх асуудалтай холбон судалж, гэр бүлд ээлтэй бодлогыг хэрэгжүүлэх тэр дундаа зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам боловсруулах аргачлал, зөвлөмжийг боловсруулахаар ажиллаж байна. Судалгааны эцсийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 22-нд хүлээн авна. Судалгааны эхний үр дүн болон дотоод, гадаадын байгууллагуудын сайн туршлагыг судлан Төрийн албан хаагчид болон аж ахуйн нэгж, байгууллагад зайнаас, цахимаар ажиллах хөдөлмөрийн дотоод журам, журам боловсруулах аргачлал, зөвлөмжийн төслийг боловсруулаад байна. Судалгааны эцсийн тайланг хүлээж авсны дараа журмын төслийг холбогдох байгууллагын төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэн батлуулна.	50
31	3.5.3.	Ахмад настныг шинэ ур чадварт сургах, ажил, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар баталсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Түр ажлын байраар хангах болон “Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ”-г хэрэгжүүлэхээр тусгасан. Үүнд: - Ахмад мэргэжилтний ажил, хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх, орлогоо нэмэгдүүлэх, эзэмшсэн мэдлэг, ажлын туршлагыг хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг сургалт, ментор, дадлагын хэлбэрээр үзүүлэх байдлаар зохион байгуулах, -Тухайн орон нутгийн ахмад настны эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг холбоо, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зөвлөх үйлчилгээ зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Дээрх арга хэмжээнд 2025 онд нийт 1725 ахмадыг хамруулах, 40 ахмадын холбоо, ТББ-ыг хамруулж, ХЭДС-аас 2.7 тэрбум төгрөгийг зарцуулна. Мөн Хувиараа хөдөлмөр эрхлэх ахмад настанд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээг өмнөх жилүүдийнхээс нэмэгдүүлж, Хүүхэд харах үйлчилгээ үзүүлэх ахмадуудын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ажиллаж байсан ажил мэргэжлийн чиглэлийг заахгүйгээр сонгон шалгаруулж ажиллах боломжийг бүрдүүлсэн. Дээрх арга хэмжээний хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар: -Ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 1094 иргэн хамрагдаж, 1,162 иргэн ажлын байраар хангагдаж, 7,586,500,000 төгрөгийг; - Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 1059 иргэн хамрагдаж, 1059 иргэн түр ажлын байраар хангагдаж, 996,039,000 төгрөгийг; - Ахмадын холбоо, төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээнд 29 ТББ хамрагдаж, 186 иргэн түр ажлын байраар хангагдаж, 271,565,800 төгрөгийг;	100

			-Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 224 иргэн хамрагдаж, 224 иргэн түр ажлын байраар хангагдаж, 299,694,800 төгрөгийг тус тус зарцуулсан байна.	
32	3.5.4.	Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд ахмад настныг ажлын байранд ажиллуулах хуулийн хэрэгжилтийг хангуулна.	УИХ-аас 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Ахмад настны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Уг хуулийг дагаж Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4-д Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 50 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт байрныхаа 2 хувиас доошгүй орон тоонд Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг газрын доор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлтэй ажлын байрнаас бусад ажлын байранд ажиллуулна гэж зохицуулалтыг тусгасан.	50
33	3.5.5.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангаж, цахимаар, зайнаас, цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 2,528 иргэн хамрагдаж, 975 иргэн ажлын байраар хангагдаж, 9,650,988,301 төгрөгийг зарцуулсан байна. Үүнээс: ·Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих цогц арга хэмжээнд 110 иргэн хамрагдаж, 1,223,764,000 төгрөгийг; ·Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд 827 иргэн хамрагдаж, 906 иргэн ажлын байраар хангагдаж, 6,194,400,000 төгрөгийг; ·Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад 1251 иргэн хамрагдаж, 125,374,524 төгрөгийг; ·Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэгийн үйл ажиллагаанд 186 иргэн хамрагдаж, 282,768,525 төгрөгийг ·Ажил олгогчийг дэмжих арга хэмжээнд 28 иргэн хамрагдаж, 28 иргэн ажлын байраар хангагдаж, 163,988,000 төгрөгийг; ·Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад үйл ажиллагаанд 68 байгууллага хамрагдаж, 1,660,693,252 тус тус зарцуулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 2025 онд 9,1 тэрбум төгрөг батлагдсанаас Хөдөлмөр эрхлэх боломжтой хөгжлийн бэрхшээлтэй хүнд хөдөлмөр эрхлэхэд зориулж хувийн туслах үйлчилгээ үзүүлэх үйлчилгээнд 740 сая төгрөгийн төсөв батлагдсан. Хувийн туслах үйлчилгээ үзүүлэхээр сонгон шалгаруулалтад тэнцсэн 9 байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна. Тус үйлчилгээнд 2025 оны 6 дугаар сард 37, 07 дугаар сард 47 хөгжлийн бэрхшээлтэй иргэн тус тус хамрагдсан бөгөөд санхүүжилтийг олгоогүй байна.	90
34	3.5.6.	Асрахуйн эдийн засгийн хөгжлийн хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн эко системийг бүрдүүлж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхдийг асрамжилж байгаа иргэний хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлнэ.	2025 онд хэрэгжүүлэх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүрээнд Гэрээс зайнаас ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ур чадварын цахим сургалтыг зохион байгуулахаар тусгасан. Мөн Бага насны /0-8 нас/ хүүхэдтэй ээжүүдийг дэмжих зорилгоор 10 хүртэлх сая төгрөгийн эргэн төлөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг тусгасан. -Түүнчлэн Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх үндэсний төлөвлөгөөг боловсруулж, батлуулахад шаардлагатай мэдээллийг цуглуулах, эмэгтэйчүүдийн болон иргэний нийгмийн байгууллагуудын санал, дуу хоолойг сонсох ажлыг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэхүү төлөвлөгөөний хүрээнд Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэхэд тулгамдаж буй асуудал болон хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас	70

		эмэгтэйчүүдийн хөгжил, хамгааллын чиглэлээр төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэл хамтын ажиллагаа сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлэгт Эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах ТББ-ууд, ОУБ, Төрийн байгууллагын төлөөллүүд оролцсон. Монгол Улсад өнөөдөр 1 сая 196 мянган хүн ажиллаж байгаагийн 563 мянга нь эмэгтэйчүүд, Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 48.6 хувь байгаа нь эмэгтэйчүүд үр хүүхэд, гэр бүлийн хүн, ахмад настнаа асрах зэрэг цалин хөлсгүй асрахуйн ажилд их цаг зарцуулдаг. Судалгаагаар Ази номхон далайн орнуудын эмэгтэйчүүд дэлхийн бусад улстай харьцуулбал 4 дахин их цагийг үнэ төлбөргүй асрахуйн ажилд зарцуулдаг байна. Ажиллах хүч дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлснээр дотоодын нийт бүтээгдэхүүнийг 26 хувиар өсгөх боломжтой. Монгол Улсын хэмжээнд 2024 оны байдлаар 15 аймаг, 6 дүүргийн хүүхэд харах үйлчилгээний төвд 315 хүүхэд асрагч эмэгтэйчүүд ажиллаж байна. Цаашид Монгол Улсад Асрахуйн эдийн засгийг хөгжүүлж, эмэгтэйчүүдийнхээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, эрх тэгш, хүртээмжтэй, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулдаг нийгмийг бий болгохыг зорих зэрэг асуудлыг хөндөж санал, зөвлөмжөө хуваалцлаа. -2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” ТББ-ын зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон эмэгтэйчүүдийн дунд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтэд нөлөөлж буй асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, санал солилцсон. -ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.1.13-т заасан “Эхчүүдэд зориулсан төрөлжсөн нийгмийн цогц үйлчилгээг төр, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлнэ.” зорилтын хүрээнд "ЭХЧҮҮД, ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ЗОРИУЛСАН НИЙГМИЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсэгт орж ажиллаж байгаа бөгөөд салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээг тус хөтөлбөрт тусгахаар ажиллаж байна. Мөн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд асрахуйн эдийн засгийг дэмжих зохицуулалтыг тусган боловсруулсан. Хуулийн төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1886 дугаар албан бичгээр хүргүүлсэн.		
35	3.5.7.	Ажлын байранд дадлагажих боломжийг нэмэгдүүлэх замаар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	2025 оны 02 дугаар сарын 11-нийн өдрийн ХЭҮЗ-ийн хурлаар батлуулсан “2025 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр”-т ажлын байран дээрх сургалт, залуучуудын ажил, хөдөлмөр эрхлэх, гарааны бизнес эрхлэх арга хэмжээг тусгасан бөгөөд гарааны бизнесийг дэмжих санхүүгийн хэмжээг нэмэгдүүлсэн. Үүний дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/50 дугаар тушаалаар Нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг баталсан. Уг үйл ажиллагааны хүрээнд гарааны бизнес эрхлэгч залуучуудын дунд улсын болон бүс нутгийн, аймаг дүүргийн уралдааныг зохион байгуулахаар тусгасан.	90

			Түүнчлэн 2025 оныг “Залуучуудын жил” болгон зарласантай холбогдуулан Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас ирүүлсэн төлөвлөгөөнд хамтран ажиллахаар саналыг тусгаж, дэмжин ажиллахаа илэрхийлсэн.	
36	3.5.8.	Урт хугацаанд ажил завсардсан болон эх орондоо буцаж ирсэн иргэдэд ур чадвар эзэмшүүлэх, мэргэшлийн зэрэг, гэрчилгээ олгох үйл ажиллагааг дэмжинэ.	Засгийн газрын 2024 оны 227 дугаар тогтоолоор Мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуулийн 17.3, 17.4 мэргэшлийн үндэсний хүрээг бүрдүүлэх, зохицуулах, хүний мэргэшлийн түвшнийг үнэлэх баталгаажуулах журмыг боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг байгуулан журмын төслийг боловсруулахаар ажиллаж байна.	50
37	3.5.9.	Гадаад улсад ажиллаж амьдарч байгаа монгол иргэдийг эх орондоо эргэн суурьшихад чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлж, бизнес эрхлэх, зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлнэ.	НҮБ-ын Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллагатай гадаадад ажиллаж, амьдарч байгаа Монгол иргэд болон Монгол Улсад ажиллаж байгаа гадаадын ажилчдын асуудлаар хамтран ажиллах чиглэлээр санал солилцон хамтран ажиллаж байна. Тус байгууллагын гадаадад суралцаж, ажиллаж байгаа өндөр ур чадвартай иргэдийг эх орондоо эргэн ирэх, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжих чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа судалгаа, туршилтын хөтөлбөрийн ажлын даалгавартай танилцан санал хүргүүлсэн. Мөн хоёр улсын Засгийн газар хооронд байгуулсан санамж бичгийн дагуу БНСУ болон Япон Улсад хууль ёсоор хөдөлмөр эрхэлж байгаа, нутаг буцах хугацаа нь дөхсөн иргэдийн судалгаа, мэдээллийг гаргах, хөдөлмөр эрхлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, холбогдох дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр холбогдох судалгааг хийж байна. Бичил, жижиг бизнес эрхлэгчдэд бизнесийн үйл ажиллагаагаа хөгжүүлэхэд зориулсан зээл, санхүүгийн дэмжлэгийг өргөтгөж, хүртээмжийг нэмэгдүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 6.3.8 дахь заалтын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэн хэрэгжүүлэх “Хөгжлийн гүүр” хөтөлбөрийг боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжсэн. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг уялдуулах хууль эрх зүйн орчин хангалттай бүрдээгүйн улмаас хөтөлбөрийг албажуулах ажил хойшилж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдан гарах хуулийн өөрчлөлтийн төсөлд холбогдох зохицуулалтыг тусгахаар ажиллаж байна. Хөгжлийн гүүр хөтөлбөрт гадаадаас эх орондоо эргэн ирсэн иргэний үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулахаар төлөвлөсөн байсан. ГБХНХЯ, ХХҮЕГ-аас БНСУ болон Япон улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад эх орондоо эргэн ирсэн иргэд, мөн гадаад улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийг бүртгэж, хөдөлмөрийн зах зээлийн мэдээ, мэдээллээр хангах, сургалтад хамрагдах, бичил бизнес эхлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2025 оны 12 дугаар сарын 5-ны өдөр “Хөдөлмөр-Хөгжил” өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгийн үеэр ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгалын бодлого, хууль тогтоомж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний талаар иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, сурталчлан таниулах, санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. Өдөрлөгт ЖДҮГ, НДЕГ, дүүргүүдийн ХХҮГ болон Япон,	90

			Солонгос хэлний сургалтын байгууллагууд оролцож 11 иргэнд үнэ төлбөргүй сургалтад хамрагдах эрхийн бичиг гардуулан өгсөн. Мөн өдөрлөгийн үеэр иргэдэд үйлчилгээг “Өртөөчилсөн булан” хэлбэрээр үзүүлсэн нь онцлог болсон ба нийт 350 иргэн үйлчлүүлсэн.	
38	3.5.10.	Ажлын байрыг шинээр бий болгосон бүс, орон нутгийн жижиг, дунд, хувиараа хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжийг төрийн бодлогоор дэмжинэ.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарыг ажлын байр хадгалах, ажлын байр нэмэгдүүлэх, үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 10-20 хүртэлх сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг хүүгүй барьцаагүй 36 сарын хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр иргэнд олгохоор санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээг тусгасан. Түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах 2025 онд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бусад баримт бичигт заасан эрх хэрэгжүүлж, үүрэг гүйцэтгэх гэрээнд дараах арга хэмжээг тусган хамтарч ажиллаж байна. Үүнд: - Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн төлөв байдлыг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил мэргэжлийн байдлаар нарийвчлан судлан тодорхойлж, хүний нөөцийн оновчтой төлөвлөлт, хуваарилалтын зохицуулалтыг хийж ажиллана; - Техник технологийн хөгжил дэвшилд тулгуурласан бүтээмж өндөртөй, инноваци шингэсэн шинэлэг санал санаачилгыг дэмжих, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ; - Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв (job center)-ийг орон нутагт нээн ажиллуулах, дэмжлэг үзүүлнэ; - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжилт авсан ААНБ, иргэдийн бараа бүтээгдэхүүнд борлуулалтын дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг шинэ төвшинд гаргаж, арга барилыг сайжруулж шинэчлэх, томоохон ААНБ-тай гэрээ байгуулж, борлуулалт хийх, хамтран ажиллах гарцыг бий болгоно; - Хөдөлмөрийн тухай хуулийн 144.3 дахь заалт, Ашигт малтмалын тухай хуулийн 43.3 дахь заалт, Ахмад настны тухай хуулийн 3 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангуулж, төвлөрсөн хөрөнгийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулах үйл ажиллагаанд зориулалтын дагуу зарцуулна зэрэг болно.	90
39	3.5.11.	Ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг, дунд бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулан үйл ажиллагааг нь хялбаршуулж, хүртээмжтэй, ил тод болгоно.	Ажлын байрыг нэмэгдүүлэх жижиг, дунд бизнесийг дэмжих зээл, зээлийн батлан даалтын тогтолцоог сайжруулах чиглэлээр Засгийн газрын 2021 оны 340 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, хүүг нь нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 267 дугаар тогтоолоор батлуулж санхүүгийн болон жижиг зээлийн хэмжээг нэмэгдүүлсэн.	90

40	3.5.12.	Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг судалж, оюутан, залуучуудын цагаар хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлж, бүс, орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, инновацад суурилсан гарааны бизнесийн хөрөнгө оруулалт, санхүүжилт /венчур сан, matching хөтөлбөр/-ийн орчныг сайжруулна.	2025 оны 02 дугаар сарын 11-нийн өдрийн ХЭҮЗ-ийн хурлаар батлуулсан “2025 оны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр”-т залуучууд, ахмад настан, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг тусгасан. Тухайлбал, залуучуудын гарааны бизнесийг дэмжих санхүүгийн хэмжээг нэмэгдүүлсэн. 2025 оныг “Залуучуудын жил” болгон зарласантай холбогдуулан Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас ирүүлсэн төлөвлөгөөнд хамтран ажиллахаар саналыг тусгаж, дэмжин ажиллахаа илэрхийлсэн. Монгол Улсын залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг оновчтой тодорхойлж, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газрын санхүүжилттэй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих YEP төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Энэхүү төслийн хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтэд тулгамдаж буй асуудлуудад дүн шинжилгээ хийж, хүний нөөцийн бодлого, бүтээмж, ажлын байрны менежментийг сайжруулах арга хэрэгслийг түгээн дэлгэрүүлж, холбогдох сургалтуудыг зохион байгуулж ажиллах бөгөөд ноос ноолуур болон зочлох үйлчилгээний салбарт туршин хэрэгжүүлэх юм. Азийн хөгжлийн банкны “Мэдлэгт тулгуурлан төсөлд инноваци, туршлагыг нэвтрүүлэх нь” техник тусалцааны төслийн дэмжлэгтэйгээр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн асуудлаарх судалгааны ажлыг хийхээр Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн А/156 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн судалгааны ажилд оролцох ОУ-ын зөвлөхүүдтэй санал солилцох зөвлөлдөх уулзалтыг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, уулзалт хийлээ. Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр YOUTHinc-Монгол Залуу Мэргэжилтнүүдийн Нийгэмлэгтэй хамтран “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн форум” YEF 2025-ыг энэ сарын 30-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Залуучуудын дуу хоолойг сонсож, ажил хөдөлмөр, ирээдүйн карьер, төлөвлөлтийн талаар хамтдаа хэлэлцэж, хүний нөөцийн болон хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн оновчтой тодорхойлох зорилготой тус арга хэмжээнд төр, хувийн хэвшил, олон улсын байгууллага, иргэний нийгмийн болон боловсрол сургалтын байгууллага, оюутан, залуучуудын төлөөлөл, нийт 200 гаруй хүн оролцсон юм. Мөн арга дээрх судалгааны үр дүнгийн танилцуулгыг “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн форум”-д танилцуулсан. Нэгдсэн форумгаар залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлагын талаар хэлэлцүүлэг хийж, хэлэлцүүлгээс гарсан асуудлыг бодлогын баримт бичигт тусгаж, хууль эрхзүйн орчны хүрээнд мөн хэрэгжилтийн түвшинд шийдвэрлэж ажиллахаар төлөвлөж байна.	90
----	---------	--	--	----

			Мөн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/50 дугаар тушаалаар Нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг баталсан. Уг үйл ажиллагааны хүрээнд гарааны бизнес эрхлэгч залуучуудын дунд улсын болон бүс нутгийн, аймаг дүүргийн уралдааныг зохион байгуулахаар тусгасан. Гарааны бизнес эрхлэгч залуучуудыг дэмжих санхүүгийн дэмжлэгийн арга хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар 466,6 сая төгрөг зарцуулж нийт 360 залуучууд хамрагдаж 58 залуу ажлын байраар хангагдсан байна. Үүнд: Гарааны бизнес эрхлэгч залуучуудад зориулан улсын уралдааныг 4 сард зохион байгуулсан. Улсын уралдаанд нийт 137 төсөл бүртгүүлснээс шилдэг 12 багийг шалгаруулан хурдасгуур хөтөлбөрт хамруулсан. Үүнээс нийт 6 баг шалгарч Улсын хэмжээний гарааны бизнесүүдэд 1 дүгээр байр (нэг баг) 20,0 сая, 2 дугаар байр (хоёр баг) 17,0 сая, 3 дугаар байр (гурван баг) 15,0 сая төгрөгийг 50%-ийн эргэн төлөх нөхцөлтэйгөөр нийт 99 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. • Бүсийн хэмжээний гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг Дорноговь, Ховд аймгуудад зохион байгуулагдаж шилдэг 6 багийг шалгаруулан 92,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. • Аймаг, дүүргийн хэмжээнд старт ап арга хэмжээнд 12 баг шалгаран нийт 180,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Мөн Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох” зорилтын хүрээнд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн байдлаар үзүүлэх, ижил стандарт бүхий “Job center” төвүүдийг байгуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод 2024 онд эхний 4 төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэхүү төвүүд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг хүн амын бүлгүүдээр төрөлжүүлж үйл ажиллагаагаа явуулж байгаагаараа онцлог юм. “Job center” төвөөр үйлчлүүлсэнээр ажилгүй иргэн, ажил хайгч иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил, мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан залуучууд, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч иргэн, гадаадад амьдарч байгаад эх орондоо болон ажил олгогч байгууллагууд нэг дор хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг авахаас гадна цагийн ажил, зайнаас ажиллах ажилд зуучлагдах боломж бүрдэнэ. “Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний Job center төвийг дэмжих туршилтын төсөл”-ийн хүрээнд 2025 онд улсын хэмжээнд 30 төвийг шинээр байгуулж, 50-иас доошгүй хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон хүн амын бүлгүүдээр төрөлжүүлэхээр төлөвлөсөн. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар Улаанбаатар хотод 10 төв, орон нутагт 4 төв үйл ажиллагаа явуулж байна.	
--	--	--	--	--

41	3.5.13.	Оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим болон зайн ажлын байрыг нэмэгдүүлэх “Бүтээмжийн хувьсгал” санаачилгыг бүх түвшинд өрнүүлж, ажилгүйдлийн түвшнийг тууштай бууруулах бодлого баримтална.	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Бүтээмжийн хувьсгал” санаачилгыг бүх түвшинд өрнүүлж, ажилгүйдлийн түвшинг тууштай бууруулах бодлого баримталж, Монгол хүний хөдөлмөрийн бүтээмж, цалин хөлсийг жил бүр нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө (2026–2035)”-ний төслийг Азийн бүтээмжийн байгууллага, Монголын бүтээмжийн холбоотой хамтран боловсруулсан. “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө”-ний төслийг танилцуулж, санал авах уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны 6 болон 8 дугаар сард холбогдох төрийн байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллүүдийг оролцуулан зохион байгуулсан юм. Эдгээр хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө”-ний төсөлд тусгасан сүүлийн хувилбарыг 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Засгийн газар, яам, агентлаг удирдах түвшний 60 гаруй албан хаагчид болон бусад оролцогч талуудад танилцуулсан. Түүнчлэн “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө”-ний төсөлд Засгийн газрын гишүүд, Үндэсний статистикийн хороо, Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо зэрэг байгууллагаас санал авахаар ГБХНХСайдын 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 01/3736 дугаар албан бичгээр хүргүүлж саналыг авч нэгтгэв. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам энэхүү “Үндэсний бүтээмжийн мастер төлөвлөгөө (2026–2035)”-ний төслийг 2026 оны 1 дүгээр улиралд Засгийн газарт танилцуулж, бүтээмжийн өсөлтөд тулгуурлан Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэс, суурийг тавих стратегийн баримт бичиг болгон батлуулна.	90
42	3.5.14.	Олон улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, хувийн хэвшилтэй хамтран хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно.	Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан “Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөрийн бирж, нийгмийн үйлчилгээний үндэсний платформыг нэвтрүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүртээмжтэй болгох” зорилтын хүрээнд улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг олон улсын жишигт нийцсэн байдлаар үзүүлэх, ижил стандарт бүхий “Job center” төвүүдийг байгуулахаар төлөвлөж, Улаанбаатар хотод 2024 онд эхний 4 төвийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Энэхүү төвүүд залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн зэрэг хүн амын бүлгүүдээр төрөлжүүлж үйл ажиллагаагаа явуулж байгаагаараа онцлог юм. “Job center” төвөөр үйлчлүүлсэнээр ажилгүй иргэн, ажил хайгч иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, ажил, мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл авах хүсэлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, оюутан залуучууд, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгч иргэн, гадаадад амьдарч байгаад эх орондоо болон ажил олгогч байгууллагууд нэг дор хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг авахаас гадна цагийн ажил, зайнаас ажиллах ажилд зуучлагдах боломж бүрдэнэ. “Олон Улсын жишигт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний Job center төвийг дэмжих туршилтын төсөл”-ийн хүрээнд 2025 онд улсын хэмжээнд 30 төвийг шинээр байгуулж, 50-иас доошгүй хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбар болон хүн амын	90

			бүлгүүдээр төрөлжүүлэхээр төлөвлөсөн. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар Улаанбаатар хотод 10 төв, орон нутагт 4 төв үйл ажиллагаа явуулж байна. Нийт-14 төв ХЭҮЗ-ийн тогтоол-1 Сайдын тушаал-1	
43	3.5.15.	Зохистой болон өндөр технологийн ажлын байрыг бий болгож, дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ.	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар 2025 онд хэрэгжүүлэх дараах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа/хөтөлбөрийг хэлэлцэж баталсан. Үүнд: Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, Түр ажлын байраар хангах болон ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа. Энэ хүрээнд албан бусаас албан хөдөлмөрт шилжүүлэхтэй бодлоготой холбоотой хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих зорилготой санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааг хэрэгжүүлж, 3300 иргэнийг хамруулж 37.1 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсөн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн төсөл, үзэл баримтлалын төслийг боловсруулах техникийн ажлын хэсгийг ГБХНХЯ-ны ТНБД-ын 2024.11.05-ны өдрийн А/128 тоот тушаалаар байгуулж төслүүдийг боловсруулж, үзэл баримтлалын төслийг ХЗДХЯ-нд 2024.11.29-ны өдрийн 01/1422 тоот албан бичгээр хүргүүлж 12 дугаар сарын 18-ны өдөр батлуулсан. Уг хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хүртээмжтэй, дэвшилтэт технологид суурилсан байх, албадан хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байх зарчмыг тусгасан бөгөөд “Албан бусаас албан хөдөлмөрт шилжих”-тэй холбоотой харилцааг тодорхой тусгасан. Хуулийн төслийг холбогдох судалгаануудын хамт боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авахаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 01/1870 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох материалын хамт 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1886 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	50
Нийт 3 зорилт 43 арга хэмжээ. Үүнээс: 100%-17, 90%-14, 70%-7, 50%-4, Ү/6-1				86.9